

УЛАМЖЛАЛ, ЗАН
ЗАНШИЛ

«ХЯТАД АРДЫН ХАВРЫН БАЯР»

Ж. Баттөр

«Хаврын баяр» «Чун жие» бол хятад ардын эртнээс уламжилж ирсэн хамгийн эрхэм хүндэт, хөлтэй их баяр ёслол юм. Урьд хаврын баяр билгийн улирлын тэргүүн сарын шинийн нэгэнд тохиох учир «шинэ жилийн баяр» хэмээн нэрлэж байгаад, 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалаас хойш хятадад нийтийн он тооллыг хэрэглэх болсноор эл баярыг аргын улирлын шинэ жилийн баяраас ялган «хаврын баяр» хэмээн нэрлэх болжээ. Хаврын баярын үүсэл байгаль дэлхийн орчил хувьсал, газар тариалангийн ажил үйлтэй нягт холбоотой. Эрт цагт, хятад хүмүүс шинэ он гарах үес, тэнгэр газрын онгод сахиулсан нарт тахил өргөн, өвөг дээдсээ дурсан хэлэлцэж, таван зүйлийн тариа будаагаар элбэг арвин, тэжээвэр амьтад нь төлөөр баян байж, овгийг уламжлагч хөвгүүд нь эсэн мэнд төрөхийг хүсэн мөргөл үйлддэг¹ байсан бөгөөд хаврын баярыг «сань юань» буюу «гурван эхэн» гэж нэрлэж байсан нь жилийн эхэн, сарын эхэн, цагийн эхэн» гэсэн утгатай ажээ.²

Ард олон хаврын баяртаа оны сүүл сараас эхлэн сайтар зэхэцгээнэ. 12 сарын найманд ихэнх айл өрх «ла ба жоу» буюу «Хөхөө сарын наймны шингэн будаа» ууна.³ «Ла ба жоуг» тутарга, шар будаа, шүлхий тутарга, шишийн цагаан, буурцаг, чавга, хушганы идээ, газрын самар зэргийг чанаж хийх бөгөөд энэ нь «ү гү фэн дэн» буюу «таван зүйлийн тариа арвин хураахыг» бэлгэдсэн утгатай ажээ. Мөн «23-нд лаагаа асаана, 24-нд гэрээ цэвэрлэнэ. 25-нд буурцага тээрэмдэнэ 26-нд махаа татна, 27-нд тахиа гаргана. 28-нд цэцэг авна, 29-нд архи авна»⁴ гэсэн дуу ч хүртэл байсан нь «хаврын баярт» хэрхэн бэлдэж байсныг харуулах ажээ.

Хаврын баяраар «шоу суй» буюу жил үдэх, «бай нянь» буюу шинэ жилийн баяр хүргэх хэмээх хятад хүн бүрийн ёсчлон дагадаг хоёр гол заншил бий. Жил үдэх ёс-шоу суй нь өмнөд хойд төрийн үед (МЭ IV—VI зуун) тогтжээ.

Жил үдэхдээ, битүүний орой элбэгдүү бэлдсэн «жилийн шөнийн хоол» идэх бөгөөд үүнд юуны түрүүн Жяо-зы (банш) идэх заншил бийг өгүүлэх хэрэгтэй буй заа. «Жяо-зы» гэдэг үгийг «хуучин шинэ 2 он солигдох цаг нь шөнийн 11—1 цаг буюу зы-цаг, жяо гэдэг нь хятад хэлний солигдох гэдэг үгтэй бичлэг, дуудлага ойролцоо тул «зя цаг солигдон ирвээ» гэсэн давхар утгатай ч гэж тайлбарлах нь бий. Хоол унд идэж уусны дараа гэр хотлоороо яриа хөөрөө дэлгэж, хөгжимдөн наадсаар шөнийн 12 цаг болмогц цаасан буу тавьж бие биедээ шинэ жилийн баяр хүргэцгээнэ. Нэгэн өрх гэрийн бага залуу улс нь ахмад хүмүүстээ тамхи, дарс, амтлаг зүйлс бэлэглэж, ахмадууд нь тэдэндээ улаан цаасанд боосон «аз жаргалын мөнгө» хайрладаг.⁵ Шинийн нэгний өдөр ах дүү, ураг садан, найз, нөхөд бие биенийдээ айлчлан амар мэндээ мэдэх ёсыг «бай нянь» буюу шинэ оноо ёслох гэнэ.

Хаврын баяраар юуны түрүүнд бүгд аав ээжийндээ цуглан ёсолж (мөргөж) дараа нь их ахындаа, улмаар дунд ах, бага ахынд тус тус очиж ёслоод, үүний дараа эгч нарындаа очино. Эцэст нь найз нөхдийнхөөрөө очно. Хятад ардын уламжлалт гурван янзын ёсолгоо бий. Үүнд:

1. Баруун гараа бүтэн атгаад, зүүн гарын алгандаа нааж, цээжин тушаа барин мэндчилэх.

2. Гараа сул атгаж, алгаа нийлүүлэн цээжинд барьж 90 хэм бөхийх.

3. Газарт сөхрөөд 2 алгаараа газар дараад гурвантаа мөргөнө. Хятад заншлаар ихэвчлэн зочлоор очсон хүн уг айлындаа бэлэг барихаас бус, тэр айл нь зочиндоо бэлэг өгдөггүй ажээ.

Баярын үеэр амттай болоод арвин идээ зоог зэхэж, ирсэн гийчин хэн бүхнийг дайлан хүндэтгэнэ. Хятад хүмүүст (шинэ) жилийн боов, (шинэ) жилийн зунз, жилийн чихэр иддэг нийтлэг заншил бий нь цаанаа бэлгэдлийн учиртай. Шинэ жилийн боов хэмээх «нянь гао» идэх нь аж төрөл, ажил үйлс нь улам улам өөдлөхийг (хятад хэлний боорцог, өндөр гэсэн 2 үг ижил дуудлагатай), шинэ жилийн зунз идэх нь өдөр бүр элбэг хоолтой, жил бүр тариа будаа арвинтай байхыг⁶ жилийн чихэр -нянь тан идэн шинэ жилээ аз жаргалтай амттайхан өнгөрөөхийг тус тус бэлгэднэ. Хятадын өмнөд нутгуудад загасан хоол зооглодог нь хамаг юм үл барагдахуйг илэрхийлнэ. Мөн түүхий лууван иддэг заншил буй нь тэр жилдээ өвчин эмгэг үл тусах болтугай гэсэн утгатай ажээ.

Баяраар «шинэ жилээ сайхан ёсолж байна уу?», «Аз жаргал хүсье» «Танд баяжихыг ерөөе» гэхчилэн мэндийн үг хэлэлцэнэ. Шинийн нэгний өдөр, ямагт ерөөсөн, бэлгэшээсэн баяр хөөртэй үг хэлэхийг эрхэмлэж, «өвчин зовлон», «үхэл хагацал» гэх мэт муу үгсийг цээрлэн, шал руу юм хум чулуудах, хутга шөвгөөр наадах оролдохыг муу ёр гэх бөгөөд болгоомжгүйтэж аяга таваг мэтийг хагалбал тэр жилдээ таагүй юмтай учрах нь хэмээн аягүйрхдэг. Хөрөнгө баялагт хоргодохыг ёрлоно гээд зүү утас хөдөлгөх, хайч барихгүй байхыг хичээдэг.

Битүүний орой Жяо Ван Е хэмээх галын бурхандаа идээ өргөн шинийн нэгэнд үүр хаяарах цагаар хашаандаа гал асаагаад арц хүж уугиулдаг нь галын бурхнаа дуудан, бүхнийг ариусгаж буй утгатай. Шөнө бүх гэрэл чийдэнгээ асаан өнгөрөөдөг.

Монголчууд цагаан сараараа цагаан өнгийг нэн дээдэлдэг бол, хятад хүн нарны хийгээд баяр баясгалангийн бэлгэдэл улаан өнгийг эрхэмлэдэг ажээ.⁷ Умард Хятадын тосгодод бүсгүйчүүл, хүүхэд багачууд нь улаан өнгийн хувцас өмсч, улаан хилэн, улаан торгоор хийсэн цэцэг үсэндээ хатгадаг.⁸ Хаврын баярын үеэр гэрт гадаа хаа сайгүй «аз жаргалын бэлгэ тэмдэг» наах бөгөөд үлэмжхэн дэлгэрсэн нь «фу» буюу «аз жаргал» гэсэн үг байна. Энэхүү үгийг урвуу харуулж наах бөгөөд, аз жаргал хүрч ирлээ гэсэн утгатай юм.

Хаврын баярын үеэр хос уянга, «Нянь хуа» зураг наах, цаасан буу тавих, «арслан» болон «лууны» бүжиг бүжих гэсэн 5 гол ёс заншил байдаг. Эдгээр нь тус бүрдээ хятадын ардын урлагийн бие даасан төрөл зүйл, соёлын өв эрдэнэ бөгөөд олон зан үйлийн ёсны салшгүй хэсэг болно.

Хос уянга дуй зы, чун мянь, дуй лян гэдэг нь улаан цаасан дээр бийрээр аз жаргалын утгатай, сайн сайхан аж төрөл, арвин их ашиг олохыг хүсэн ерөөсөн үг бичих заншил юм. Энэхүү заншил нь Таван үе Арван төрийн үед (907—960 он) үүссэн гэх бөгөөд⁹ Мин улсын (1368—1644) анхны хаан Жу Юаньжан хаврын хос уянга шимтэн сонирхож, хамаг түшмэд албат бүр хаалга үүдэндээ «чунь лян-хаврын хос уянга» наагтун хэмээн зарлиг буулгаснаар энэ ёс дэлгэрч, өвөрмөц сайхан заншил болон түгжээ. Хос уянгыг хаврын баяраар төдийгүй, хурим той, оршуулгын үйл, бусад баярын үед хаалга үүд-

нээс гадна өрөө танхим, хана туурга, нуруу багананд хүртэл наадаг. Хос уянга бичих ёс нь нарийн журам горимтой. Үүнд хаалганы баруун зүүн талд, дээрээс доошоо, тав, долоо, ес, арван нэгэн үгтэй (сондгой тоог) өгүүлбэр бичин, баруун талынхыг дээд уянга, зүүн талынхыг доод уянга гэх бөгөөд хаалганы тотгонд хадсан дөрвөн үгээс бүтсэн уянгыг хөндлөн уянга гэнэ. Хос уянгад эрт өдгөөгийн нэрт яруу найрагчдын шүлгээс аваад ардын ерөөл дэмбэрэлийн үгсийг бичнэ. Тухайлбал (дээд уянга): «Шатах хулсны дуунаар хуучин оноо үднэм» (доод уянга) «Лавсах цасны үзэсгэлэнд шинэ оноо угтнам» гээд хөндлөн уянгад «Түмэн бодис шинэхэн болмуй» гэх буюу «Буян жаргал ину дорнод тэнгист цутгах их усан мэт арвижих болтугай» «Эд баялагийн эх булаг ану гурван мөрнийг бүрхэх мэт бялхах болтугай» гээд хөндлөн уянгад: «Машид босч, ашид баяж» гэж бичих жишээтэй.

«Нянь хуа» буюу «оны зураг» гэдэг нь мөрөг загас тэвэрсэн мяраалаг хүүхэд, луун завины уралдаан, байгалийн үзэсгэлэн, шувуу цэцэгс, таван зүйлийн тарианы арвин хурааж буй зэрэг сэдэвтэй, зураас будгийн зохицол энгийн төв, өнгө хурц тод, баяр хөөр аз жаргалыг бэлгэдсэн утгатай зураг бөгөөд үүнийг айл болгон шахуу гэр орондоо наадаг.

Хятадад Тяньжин хотын Ян лю чинь нянь хуа, Шаньдун мужийн Вэй Фань Нянь Хуа, Гуандун мужийн Фо шань нян хуа гэхчилэн мөнхүү урлагийн алдартай газрууд байдаг юм.¹⁰

Хаврын баярын үеэр болдог үлэмж дэлгэрсэн ёслолын нэг нь Бянь пао, пао жан, пао жу гэхчилэн нэрлэх «цаасан буу буудуулдаг заншил болно. Энэ ёс одоогоос 200 жилийн тэртээ үүсчээ. Анх хулс шатаадаг («пао жу») байсан бөгөөд асч буй хулсны тас няс дуунаар муу зүгийн юмс тонилж аз жаргал ирдэг хэмээн сүсэглэдэг байжээ. Тан улсын (618—907) үед дарь хийх аргыг мэддэг болсноороо хулсандаа дарь хийн чимээ сүрийг улам ихэсгэн, Сүн улсын (1127—1279) үед хулсны оронд цаас ашигладаг болсон. Тийнхүү «Хулс асаах» гэсэн утгатай «Пао жу»-гаа өөрчлөн «пао жан» хэмээн нэрлэдэг болжээ. Цаасан бууг улаан цаасаар бүрэх бөгөөд дэлбэрч цацарсны дараа газраар нэг улаан цаасны үртэс болж, тэр нь аз хийгээд ашиг орж ирснийг илэрхийлнэ. Цаасан буу нь зуу, мянга, түмэн толгой (хэсэг) болон задардаг, тэнгэрт цойлдог, цахилгаан гэрэл цацруулдаг, элдэв хэлбэр дүрс, «утаан цэцэг» гаргадаг гэхчилэн олон янз төрөл байдаг.¹¹

Хаврын баяраар нааддаг лууны болон арслан бүжиг нь хэн хүний үзэх дуртай урлагийн сайхан тоглолт юм. Ер нь луу, арслан нь дөрвөн их хүчтэнд багтан сүр хүч, ялан дийлэхүй аз өлзийг бэлгэдэх бөгөөд нийт дорнодахины улс орнуудад өргөн тархсан бэлгэдэл зүйн чухал дүр юм. Луу бол хүн ардад хур бороо хайрлан, тариан талбайг нь усжуулан тэтгэж тариачин олныг байгалийн гамшгаас хамгаалж, жаргал хайрладаг домгийн сүр хүчин төгөлдөр амьтан бөгөөд, тэнгэр газрын дараа орох гуравдахь их шүтээн юм.¹² Лууг могойн биетэй бугын эвэр, бүргэдийн савар, морины нүүр, тэмээн толгой, молтогчин туулайн нүдтэй, чих нь үхрийнхтэй адил сахалтай байдлаар дүрсэлдэг. Ертөнцөд тэнгэр бурхдыг харан хамгаалж байдаг тэнгэрийн луу, салхи бороо илгээдэг тэнгэрлэг луу, гол мөрний гүн болон урсгалынх нь чигийг заадаг газрын луу, эрдэнэсийн сан сахигч луу гэсэн дөрвөн янзын луу байх бөгөөд, луу нь явж, сэлж, нисч чаддаг ажээ.¹³ Луун бүжиг нь одоогоос долоон зууны тэртээ өмнөд Сүн улсын үед үүсчээ. Лууны араг биеийг хулс, шор, төмөр, сэлтээр үйлдэн өнгө өнгийн гялгар зүйлс, торгоор бүрж гадна төрхийг нь тун сайхан урлан, хайрс

хээ чимэг зэргээр чимж, лууныхаа дотор лаа асаан, нүдэнд нь чийдэн хийж, харанга бөмбөрийн нижигнээн дунд бүлэг хүн тогтож дадсан хөдөлгөөнөөр амьд мэт хөдөлгөн, бахдам сүрлэг бүждэг. Лууны нийт урт 15 м хүртэл байх бөгөөд толгой нь 3 м өндөр байна.

Эцэст нь арслан бүжгийн тухай өгүүлэе. Энэ бүжиг нь дотроо умардын болон өмнөдийн гэсэн үндсэн хоёр дэгд хуваагдан дотроо хэд хэдэн сургууль болж сална. Умардын арслан бүжиг нь 1500-гаад жилийн тэртээ хойд Вэй улсын үед умар зүгийн нүүдэлчин нараас хятад оронд дэлгэрч, Вэй улсын хаан сайхь бүжгийг «Хойд Вэйгийн билигт арслан» хэмээн өөрчлөн нэрлэсэн ажээ.¹⁴ Өмнө зүгийн арслан бүжиг нь МЭ 420-479 онд засаглаж байсан өмнө төрийн Сүн улсын үед үүссэн. Тэр цагт хятадууд Линь-и нар руу довтлох үестээ, заан унасан цэргүүдэд нь сүрхий цохигдож, удалгүй арслангийн өмсгөл хийн нөмөрч, заануудыг нь айлган дутаалгаж Линь и нарыг ялснаас хойш Зөвхөн цэргүүдийн дунд бүждэг байгаад хожим нь ард нийтийн бүжиг болон дэлгэрч, биеийн тамирын наадам болохын зэрэгцээ аз өлзийн бэлгэдэл болжээ.¹⁵ Умар зүгийн бүжигт хоёр хүн арслангийн өмсгөл нөмрөг (эсвэл нэг хүн гүюгийн* өмсгөл нөмөрч) өөр нэг бүжигчин баатар эрийн хувцас өмсч гартаа Сю чю буюу модонд бэхэлсэн бөмбөлөг барин удирдан наадна. Умар зүгийн арслан бүжигт арслантай хамт бүжиглэж буй бүжигчид нь том тэргүүнтэй бурханы нигуур² бүхий өмсгөл өмсөн бүжиглэдэг байна. Арслан бөмбөр, цан, харангын нижигнээн дунд дүүлэх, өнхрөх, харайх, биеэ газарт шөргөөх зэрэг боловсруулж тогтсон хөдөлгөөн үзүүлэхээс гадна, бөмбөлөг дээр тэнцвэр олох, банзан дээгүүр харайх, нэг тавцангаас нөгөө рүү нь дүүлэх зэргээр наадан, удирдан буй бүжигчин нь хөнгөн тамирын (акробатын) уран чадварлаг хөдөлгөөн хийж сонирхуулна.

1-Арслангийн зулзагыг гүюг гэнэ.

2-Нигуур-нүүр гэсэн үгийн хүндэтгэлийн хэлбэр

1. В. Я. Сидихменов «Китай страницы прошлого» М., 1974

2. Шу Шу Ань нар «Жунго Вэньхуа жи ши» («Хятадын соёлын мэдлэг») 1987,

291-р тал

3 «Жунго минь жэнь жиери» Бээжин 1-р бүлэг

4. Шу Шу Ань нарын ном 292-р тал

5. Traditional Chinese Festivities by Gao Bian (хятадын уламжлалт баяр ёслолууд)

"Chinese youth" сэтгүүл, 1987. П сар.

6. Шу Шу Ань нарын ном, мөн тэнд

7. В. Я. Сидихменов. стр. 246

8. В. Я. Сидихменов стр. 246

9. Шу Шу Ань нарын ном 293-р тал

10. Мөн ном, 294-р тал

11. Мөн ном, 295-р тал

12. Сидихменов В. Я. стр. 11

13. Мөн тэнд, стр. 11

14. Шу Шу Ань нарын ном 295, 296-р тал

15. Intermediate Chinese Volume I 140 p.